



# ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГАД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА

ҮНЭГҮЙ ТАРААГДАНА





# 1 ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ



Санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх олон улсын байгууллага /ФАТФ/-ын 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хурлаар Монгол Улс мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр стратегийн дутагдалтай орнуудын жагсаалтад орсон тул үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагааны бодлого стратеги, зохицуулалтыг сайжруулах зорилтын хүрээнд УИХ-аас 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль болон Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулснаар **“үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа”**-г тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаанд хамааруулж зохицуулах, хяналт тавих үүргийг Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлэхээр хуульчлагдсан.

- ☑ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7-д “үл хөдлөх хөрөнгө худалдан авах, эсхүл худалдах аливаа ажиллагаа явуулсан бол үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага”;
- ☑ Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.21.2-т “үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа”;
- ☑ Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.10-т “үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа”;

# 2

## “ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ЗӨВШӨӨРӨЛ, ЭРХ ОЛГОЛТ, БҮРТГЭЛИЙН ЖУРАМ”-ЫН ЗОРИЛГО

- ☑ Санхүүгийн зохицуулах хорооны 120 дугаар тогтоолоор “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам”-ыг баталсан;
- ☑ Санхүүгийн зохицуулах хорооны 179 дүгээр тогтоолоор “Банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох журам”-ыг баталсан;
- ☑ Санхүүгийн зохицуулах хорооны 181 дүгээр тогтоолоор “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”-ыг баталсан.



Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хорооноос үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах шаардлагыг тодорхойлох, тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, бүртгэх, тэдгээрийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой нарийвчилсан харилцааг зохицуулахад оршино.

## 3 ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨРӨЛ

- ✓ Үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийг худалдах, худалдан авах, шилжүүлэх үйл ажиллагааг зуучлах;
- ✓ Үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийг түрээслүүлэх, түрээслэх, хөлслүүлэх, хөлслөх үйл ажиллагааг зуучлах;
- ✓ Үл хөдлөх эд хөрөнгийн менежментийн үйлчилгээ;
- ✓ Үл хөдлөх эд хөрөнгийг худалдан авч, засварлан борлуулах үйлчилгээ;
- ✓ Хорооноос үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйл ажиллагаанд хамаарна гэж үзсэн бусад үйлчилгээ.



Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд эрхлэх бөгөөд зөвхөн үл хөдлөх эд хөрөнгийн салбарт үйл ажиллагаа эрхлэхийг анхаарна уу.

## 4 ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХОД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- ✓ Компанийн тухай хуульд заасны дагуу үүсгэн байгуулагдсан, улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн байх;
- ✓ Хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангасан байх;
- ✓ Энэхүү хувь нийлүүлсэн хөрөнгө нь хууль ёсны орлого байх бөгөөд зээлийн эх үүсвэрээс бүрдээгүй болохыг нотлох баримт бичгийг ирүүлэх;
- ✓ Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбарт 2-оос доошгүй жил ажилласан туршлагатай, агентуудыг мэргэшил, арга зүйгээр хангах чадамж бүхий 1-ээс доошгүй брокертой байх;
- ✓ Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй 1-ээс доошгүй агенттай байх;
- ✓ Брокер, агент нь Хорооноос баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу зохион байгуулагдсан сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцэж, гэрчилгээ авсан байх;
- ✓ “ТОХИРОМЖТОЙ ЭТГЭЭД” гэж Хорооны 2020 оны 179 дүгээр тогтоолоор баталсан “Банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох журам”-д заасан нөхцөл, шаардлагыг хангасан этгээдийг хэлнэ.



### ХУУЛИЙН ЭТГЭЭД БОЛ:


1. Санхүүгийн тогтвортой байдал, төлбөрийн чадвартай байх;
2. Бодлого, зохицуулалт баталгаатай байх;
3. Төрийн эрх бүхий байгууллагаас албадлагын эсхүл захиргааны шийтгэлгүй байх;
4. Бизнесийн болон ёс зүйн нэр хүндтэй байх;
5. Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;
6. Хуульд заасан бусад.
7. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажилтан томилсон байх;
8. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйл ажиллагаа явуулах ажлын байр, техник, тоног төхөөрөмж, програм хангамжтай байх;
9. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйл ажиллагааг зохицуулсан дотоод журам, ажилтнуудын ёс зүйн журам батлах;
10. Дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр батлах /Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т заасан шаардлагыг хангасан байх/;
11. Бизнес төлөвлөгөөтэй байх;
12. “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам”-ын 1 дүгээр хавсралт дахь маягтын дагуу өргөдөл гаргаж, 4 дүгээр хавсралтад заасан баримт бичгийг үнэн зөв, бүрэн гүйцэд бүрдүүлэн Хороонд ирүүлсэн байх.

### ХУВЬ ХҮН БОЛ:

1. Мэдлэг боловсрол, ажлын туршлагатай байх;
2. Гэмт хэрэгт холбогдож байгаагүй байх; /Журмын 3.2.2-т заасныг/
3. Ёс зүйн нэр хүндтэй байх; /Журмын 3.2.3-т заасныг/
4. Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх; /Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд харшлаагүй/
5. Хуульд заасан бусад.

# 5 ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХҮСЭЛТЭД ХАВСАРГАХ БАРИМТ БИЧИГ

№	Баримт бичгийн төрөл	Товч тайлбар
1	Тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлт /албан бичиг/	Хуулийн этгээдийн тусгай зөвшөөрөл хүссэн албан бичгийн доод хэсэгт Хороонд хүргүүлж буй холбогдох баримт бичгийн хуудасны тоог бичнэ.
2	Журмын 1, 12, 13 дугаар хавсралт	Маягтыг үнэн зөв, бүрэн гүйцэд, гаргацтай мэдээлэх.
3	Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйл ажиллагаа эрхлэх тухай шийдвэрийн эх хувь эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хуулбар	2 болон түүнээс дээш хувьцаа эзэмшигчтэй тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлийг хавсаргах.
4	Тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар	
	<p>Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хувьд Гадаадын хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн байгууллагаас олгосон гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбараас гадна дараах бичиг баримтыг ирүүлнэ.</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Харьяалах улс, оронд зээл, батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй болохыг нотлох баримт бичиг;</li> <li>2. Харьяалах улс, оронд гааль, татварын өртэй эсэхийг харуулсан баримт бичиг;</li> <li>3. Харьяалах улс, оронд ял шийтгэлгүй болохыг нотлох баримт бичиг;</li> <li>4. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа, гэмт хэрэгт оролцож байгаагүй болохыг нотлох баримт бичиг.</li> </ol>	Монгол хэлний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй албан хэргийг монгол хэлээр хөтлөн явуулна” гэж заасны дагуу тусгай зөвшөөрөл хүсэж ирүүлсэн баримт бичгийн бүрдэлд байх гадаад хэл дээрх баримт бичгийг албан ёсны баталгаат орчуулга хийлгэж ирүүлэх.



№	Баримт бичгийн төрөл	Товч тайлбар
5	<p>Улсын бүртгэлд бүртгүүлсэн компанийн дүрэм</p> <p>Шинэчилэн батлах дүрэмд Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлд зааснаас гадна дараах зүйлийг тусгасан байна:</p> <ol style="list-style-type: none"><li>1. хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах нөхцөл;</li><li>2. хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах журам, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхэд баримтлах журам, энэ талаарх удирдлагын бүрэн эрх;</li><li>3. хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл болон Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажилтны эрх, үүрэг, хариуцлага;</li><li>4. хувьцаа арилжих, бусдад шилжүүлэх, харилцан хязгаарлалт хийх үйл ажиллагааны зохицуулалт;</li><li>5. татан буугдах үндэслэл, удирдлага, брокер, агентийн буруутай үйл ажиллагаанаас хөрөнгө оруулагч, харилцагчдад учруулсан хохирлыг барагдуулах арга хэлбэр, хариуцлага хүлээх зарчим.</li></ol>	<p>Улсын бүртгэлд бүртгүүлсэн дүрэм гэдэг нь тусгай зөвшөөрлийн хүсэлтийг Хороонд гаргахаас өмнөх үйл ажиллагаандаа мөрдөж байсан дүрмийг хэлнэ. /Тусгай зөвшөөрөл авах үеийн шинэчилэн баталсан дүрмийн төслийг Улсын бүртгэлд бүртгүүлэх шаардлагагүй/.</p> <p>Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт орох тухай бүр Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрөл авах зохицуулалтыг тусгах.</p> <p>Компанийн тухай хуульд нийцүүлнэ.</p> <p>Компанийн тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөртэй нийцүүлэх</p> <p>Компанийн тухай хууль, Иргэний хуульд нийцүүлэх</p> <p>Компанийн тухай хуульд нийцүүлэх бөгөөд брокер, агентийн буруутай үйл ажиллагаанаас хөрөнгө оруулагч, харилцагчдад учруулсан хохирлыг барагдуулах арга хэлбэр, хариуцлага хүлээх зарчмыг дүрэмд тусгах</p>




№	Баримт бичгийн төрөл	Товч тайлбар
6	Хувь нийлүүлсэн хөрөнгийн эх үүсвэр нь хууль ёсны орлогоос бүрдсэн болохыг нотлох бичиг баримт, гарал үүслийн талаарх тайлбар, тодорхойлолт	Хууль ёсны орлого гэдэг нь татвар төлсний дараах орлогыг хэлнэ. Жишээлбэл: 1. Цалин-нийгмийн даатгалын ТҮЦ машины лавлагаа, дансны хуулга, хөрөнгө худалдан борлуулсан бол худалдах худалдан авах гэрээ, татвар төлсөн баримт-дансны хуулга; 2. Ногдол ашиг бол хувьцаа эзэмшигчдийн шийдвэр, дансны хуулга, санхүүгийн тайлан, ХХОАТ төлсөн баримт гэх мэт.
7	Хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл	1. Харилцагч нь хуулийн этгээд бол тухайн хуулийн этгээдийн хөрөнгийн дийлэнх хэсгийг дангаараа, эсхүл бусадтай хамтран өмчилж байгаа; 2. Тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж, эсхүл өөрийн үйлдлийг бусдаар төлөөлүүлэн хийлгэж байгаа; 3. Хуулийн этгээдийг болон уг хуулийн этгээдээс хийх аливаа хэлцэл, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдах замаар тухайн хуулийн этгээдийг өмчилж үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг эцсийн өмчлөгч гэнэ.
8	Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгөд ногдох мөнгөн хөрөнгийг өөрийн харилцагч банкны дансанд байршуулсан талаарх банкны тодорхойлолт, бусад баталгаа	Банк дахь харилцах, хадгаламжийн дансны хуулга, тодорхойлолт.
9	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14.1-т заасан дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр	Хөтөлбөрийн жишиг загвартай дараах холбоосоор танилцана уу. <a href="http://www.frc.mn/a/3189">http://www.frc.mn/a/3189</a> Өөрийн компанийн үйл ажиллагааны онцлог, цар хүрээнд нийцүүлэн батлах.
10	Сүүлийн жилийн санхүүгийн тайлан, шинээр үүсгэн байгуулагдсан бол эхлэлтийн баланс	Өмнө нь үйл ажиллагаа эрхэлж байсан компанийн хувьд Хороонд хүсэлт гаргахын өмнөх улирлын санхүүгийн тайланг ирүүлэх.
11	Эцсийн өмчлөгч, хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий албан тушаалтан нь энэ журмын 12, 13 дугаар хавсралтын дагуу гаргасан тодорхойлолт	Брокер, агентууд, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажилтан /комлаенсын ажилтан/ нь 12 дугаар маягыг үнэн зөв, бүрэн гүйцэд мэдээлэх.

№	Баримт бичгийн төрөл	Товч тайлбар
12	Ажлын байр нь компанийн өөрийн байр бол үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, түрээсийн байр бол түрээсийн гэрээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.6-д “үйл ажиллагаа явуулах барилга байгууламжийн гаднах орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор дүрс бичлэгийн техник, хэрэгсэл суурилуулж, энэ талаар цагдаагийн байгууллагын саналыг авсан байх” гэж заасны дагуу Цагдаагийн байгууллагаас гаргасан тодорхойлолт
13	Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан дотоод журам, ажилтнуудын ёс зүйн журам;	Холбогдох журмуудыг баталсан шийдвэрийн эх хувь, эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг заавал ирүүлэх
14	Бизнесийн төлөвлөгөө	Бизнес төлөвлөгөөнд дараах зүйлийг тусгана: 1.Компанийн танилцуулга; 2.Зах зээлийн судалгаа; 3.Төлөвлөсөн бизнесийн үйл ажиллагаа; 4. Санхүүгийн шинжилгээ.
15	Үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн дотоод зохион байгуулалтын бүтэц, танилцуулга	Схемчилсэн байдлаар компанийн бүтцийг харуулах /компанийн засаглал/
16	Үндсэн үйл ажиллагаанд ашиглах техник тоног төхөөрөмжийн жагсаалт	Тоног төхөөрөмж худалдан авсан үнийн дүнг тусгах
17	Энэ журмын 5.1 дэх хэсэгт заасан этгээдүүд нь тохиромжтой этгээдийг тодорхойлох шалгуурыг хангасан эсэхийг нотлох баримт	“Банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох журам”-ын 1, 2 дугаар хавсралтаар баталсан асуулгад бүрэн, гүйцэд, үнэн зөв хариулах. <a href="http://www.frc.mn/resource/frc/Document/2020/05/12/xz5oxivior233l9b/179.pdf">http://www.frc.mn/resource/frc/Document/2020/05/12/xz5oxivior233l9b/179.pdf</a> Эцсийн өмчлөгч, хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан, брокер, комлаенсын ажилтан нь ЦЕГ, ТЕГ, ШШГГ-ын тодорхойлолтыг ирүүлэх

# 6

## ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗАЙНЫ БОЛОН ГАЗАР ДЭЭРХ ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ ЖУРАМ

Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хорооноос үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа, санхүүгийн байдалд хяналт, шалгалт хийж, холбогдох хууль тогтоомж, журам, зааврын хэрэгжилт, учирч болзошгүй эрсдэлийн түвшинг тодорхойлон үнэлгээ, дүгнэлт өгч, илэрсэн зөрчил дутагдалд холбогдох арга хэмжээ авахад оршино.



Газар дээрх хяналт, шалгалтаар зуучлалын байгууллагын үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомж, журам зааварт нийцэж байгаа эсэхийг газар дээр нь баримтаар тогтоож, илэрсэн зөрчил дутагдалд холбогдох арга хэмжээг авна.

<b>ГАЗАР ДЭЭРХ ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН АНГИЛАЛ</b>	Иж бүрэн, хэсэгчилсэн
<b>ШАЛГАЛТ ЭХЛЭХ</b>	Удирдамжийг шалгалтад хамрагдах зуучлалын байгууллагад танилцуулснаар шалгалтыг эхлүүлнэ
<b>ИЖ БҮРЭН ХЯНАЛТ, ШАЛГАЛТ</b>	Шалгалтад хамрагдаж буй зуучлалын байгууллагаас журмын 3.6.1-3.6.10-т заасан баримт бичгийг шаардана.
<b>ХЭСЭГЧИЛСЭН ХЯНАЛТ ШАЛГАЛТ</b>	Хэсэгчилсэн хяналт, шалгалтад хамрагдах зуучлалын байгууллагаас удирдамжид заасан баримт бичгийг шаардана.
<b>ШАЛГАЛТЫН ТАЙЛАН</b>	Журмын 3.8-3.10 дахь заалтуудад шалгалтын тайлан, үүрэг даалгаврын биелэлтийн талаар тусгасан.



Зайны хяналт, шалгалтаар салбарын болон зуучлалын байгууллагын болзошгүй эрсдэлийг тодорхойлж, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.



Санхүүгийн тайлан болон комплаенсын эрсдэлийн үнэлгээний тайланг хагас, бүтэн жилээр гаргаж Хороонд ирүүлнэ



Бизнесийн болон бүтцийн эрсдэлийн үнэлгээний тайланг улирал бүрийн дараа сарын 10-ны өдрийн дотор Хороонд ирүүлнэ.



Журмын 4.3.1-4.3.5-д заасан үндсэн үйл ажиллагааны мэдээг сар бүр гаргаж, дараа сарын 10-ны өдрийн дотор Хороонд цахимаар ирүүлнэ




Журмын 4.3.6-д заасан мэдээлбэл зохих гүйлгээ, харилцагчийн бүртгэлийн мэдээг сар бүр гаргаж, дараа сарын 10-ны өдрийн дотор Хороонд цахимаар ирүүлнэ







Гэмт хэрэгтнүүд их хэмжээний бэлэн мөнгийг дараах хууль бус үйл ажиллагаанаас олдог бөгөөд тэр нь мөнгө угаах гэмт хэргийн үндэс болдог. Үүнд:

- Хууль бус галт зэвсгийн наймаа
- Хүний, эд эрхтний наймаа
- Хар тамхины худалдаа
- Бусдын биеийг үнэлүүлэх
- Мөнгөн тэмдэгт хуурамчаар үйлдвэрлэх
- Авлига, хээл хахууль
- Татвараас зайлсхийх
- Байгаль орчны эсрэг, гэмт хэрэг
- Хулгай, дээрэм
- Цахим гэмт хэргийн хохирогчоос шаардаж авсан барьцаа төлбөр, криптовалютаар олсон орлого гэх мэт



Дээрх гэмт хэргийг үйлдэж олсон хууль бус орлогыг гэмт хэрэгтнүүд бэлэн мөнгө хэлбэрээр хадгалах нь дараах “эрсдэлүүдийг” дагуулдаг.

- Их хэмжээгээр тээвэрлэх, хадгалахад хүндрэлтэй
- Сэжиг төрүүлэхгүйгээр зарцуулахад хүндрэлтэй
- Хулгай, дээрэмд өртөж болзошгүй
- Их хэмжээгээр олдсон тохиолдолд сэжиг төрүүлнэ




Иймд гэмт хэрэгтнүүд хууль бус үйл ажиллагаанаас олсон орлогоо мэдээлэх үүрэгтэй этгээд эсвэл, хууль хяналтын байгууллагын анхаарлыг татахгүй, тэдний хараанд өртөлгүйгээр зарцуулах боломжтой болохын тулд санхүүгийн системд нэвтрүүлж, жинхэнэ эх үүсвэрийг нь нуун дарагдуулж, төөрөгдүүлэх замаар хууль ёсны орлого мэт харагдуулахыг зорьдог.

# 8

## МӨНГӨ УГААХ ТЕРРОРИЗМИЙГ ЯАЖ БАГАСГАЖ СААРУУЛАХ ВЭ?

- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон бусад хууль журмыг дагаж мөрдөх;
- Санхүүгийн зорилтот арга хэмжээг хэрэгжүүлдэг байх;
- Санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ; үзүүлэгчид, тэдгээрийн удирдах, нөлөө бүхий албан тушаалтан, эцсийн өмчлөгчийг тохиромжтой эсэхийг тогтоодог байх;
- Олон нийт ийм төрлийн гэмт хэргийн талаар мэдлэг мэдээлэлтэй байх;
- Мэдээлэх үүрэгтэй этгээдүүд нь хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх.



Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “дараах этгээд энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан гүйлгээний талаар энэ хуулийн 16.1-д заасан Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй” гэж заасны дагуу үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага нь 7 дугаар зүйлд заасан гүйлгээг мэдээлнэ. Үүнд:

7.1.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй.

7.2.Хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол энэ хуулийн 4.1-д заасан этгээд энэ тухай 24 цагийн дотор сэжигтэй гүйлгээний тухай батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ.

7.3.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд болон Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 13, 14 дүгээр зүйлд заасан этгээд мэдээллийг Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэл ирүүлэх журам, маягтын дагуу цахим хэлбэрээр ирүүлнэ. Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэл ирүүлэх журам, маягтыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны даргын саналыг үндэслэн Монголбанкны Ерөнхийлөгч батална. /Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны А26 тушаал/

7.4.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд Монголбанкны Ерөнхийлөгч, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтран баталсан мэдээлэл өгөх журмын дагуу тодорхой гүйлгээ, түүнд оролцогч талуудын тухай мэдээллийг эрх бүхий хууль сахиулах болон терроризмтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагад гаргаж өгнө.

7.5.Энэ хуулийн 4.1-д заасан этгээд шаардлагатай тохиолдолд Санхүүгийн мэдээллийн албаны даргын зөвшөөрснөөр цаасан хэлбэрээр ирүүлж болно.

